



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 08 сарын 11 өдөр

Дугаар А/108

Улаанбаатар хот

Хүн, малын гоц халдварт болон
тарваган тахал өвчнөөс урьдчилан
сэргийлэх талаар авч хэрэгжүүлэх
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8 дахь заалт, Амьтны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.9 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1064 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Байгалийн голомтот хүн, мал, амьтны гоц халдварт болон тарваган тахал өвчний халдвар тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд замын цагдаагийн хяналтын постыг түшиглэн мэргэжлийн байгууллагуудын ажилтнаас бүрдсэн хяналт шалгалтын ажлыг 24 цагаар зохион байгуулж ажиллуулахыг Цагдаагийн хэлтэс (Т.Лхагвасүрэн), Эрүүл мэндийн төв (Х.Ганбат), Мал эмнэлгийн тасаг (Д.Шүрэн-Эрдэнэ)-т болон өдөр тутмын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Онцгой байдлын хэлтэс (Б.Цогбадрах)-т тус тус үүрэг болгосугай.

2. "Хяналт шалгалтын хэсэг"-ийн ажиллах зааврыг нэгдүгээр, ажиллах бүрэлдэхүүнийг хоёрдугаар, хөдөлгөөнт эргүүлээр ажиллах онцгой комиссын гишүүдийн хуваарийг гуравдугаар, шаардагдах зардлын төсвийг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

3. Дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

3.1 Эрүүл мэндийн байгууллагын бэлэн байдлыг ханган сургалт, сурталчилгаа явуулах, эрсдэлтэй ажил гүйцэтгэдэг мэргэжлийн байгууллагын албан хаагчдыг тарваган тахал өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулахыг дүүргийн Эрүүл мэндийн төв (Х.Ганбат)-д

3.2 Байгалийн голомтот болон амьтнаас халдварладаг өвчнөөс учрах аюул, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн ажил, хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т

4. Тарваган тахал болон хүн, мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх эргүүл, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулахад шаардагдах 1,756,800 (нэг сая долоон зуун тавин зургаан мянга найман зуун) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Тамгын газрын ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Х.Цогцэцэг)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

АЖИЛ 2025 он ажил захирамж

1225010682

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 08 сарын 11 -ны өдрийн
А/Б.8 захирамжийн нэгдүгээр хавсралт

ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗААВАР

Нэг. Зорилго

Энэхүү зааврын гол зорилго нь нийслэл, дүүрэгт хүн, мал, амьтаны гоц халдварт тарваган тахал өвчин тархахаас урьдчилан сэргийлэх, холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулахад оршино.

Хоёр: Хяналтын үйл ажиллагааг зохион байгуулах байршил

Тарваган тахал өвчний халдвар зөөгдөн орж ирэх нөхцөл, халдвар судлалын холбогдлыг харгалзан хяналт шалгалт явуулах цэгийг 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн дор дурдсан хэлбэрээр зохион байгуулна. Үүнд:

2.1. “Хяналт, шалгалт явуулах ажлын хэсэг”-ийг Багахангай дүүргийн Замын цагдаагийн хяналт шалгалтын цэгт Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн хэлтэс, Замын цагдаагийн алба, Мал эмнэлэгийн тасаг хамтран 24 цагаар 3 ээлжээр зохион байгуулан ажиллуулна.

2.2. Хяналтын хөдөлгөөнт эргүүлийг дүүргийн нутаг дэвсгэр болон цагдаагийн суурин пост, болон дүүрэг рүү ордог баталгаат бус замуудад цагдаа, хэв журам сахиулах албадтай хамтран зохион байгуулна.

Гурав. Үйл ажиллагааны, зохион байгуулалт

3.1. Зоонозын өвчин судлалын үндэсний төв нь тарваганы мах болон түүний гаралтай бүтээгдэхүүн илэрсэн тухай мэдээллийн дагуу эхний ээлжинд хүрэлцэн очих дуудлагын багийг 24 цагаар, тандалт хийх хөдөлгөөнт багийг тодорхой хугацаагаар тогтмол ажиллуулан халдвар эсэргүүцэх арга хэмжээг шуурхай зохион байгуулж, халдварын эрсдэлтэй материалын дээжинд хийсэн шинжилгээний хариуг цаг алдалгүй гаргаж, үүссэн нөхцөл байдлыг нийслэлийн Онцгой байдлын газар, дүүргийн Онцгой байдлын хэлтсийн /80009101, 80105580, 7049101/ дугаарын утсанд мэдээлж ажиллана.

3.2. Хяналтын хөдөлгөөнт эргүүлийг мэргэжлийн байгууллагууд дүүргийн нутаг дэвсгэрт 14 хоног тутамд хяналт тавьж, шалгалтын дүнг илтгэх хуудсаар дүүргийн Онцгой комиссын даргад танилцуулна.

3.3. Дүүргийн нутаг дэвсгэрт тарваганы мах, мал, амьтны түүхий эд, дайвар бүтээгдэхүүн оруулан ирж байгаа үйлдлийг таслан зогсоож, хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг газар дээр нь арилгуулж, иргэдэд сэрэмжлүүлэх мэдээлэл, сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулна.

3.4. Авто тээврийн шалган бүртгэх товчоогоор нийслэл дүүрэгт орж ирэх бүх төрлийн тээврийн хэрэгсэл, зорчигчдын ачаа тээшинд үзлэг шалгалт хийж, тарваганы арьс түүхий эд илэрсэн тохиолдолд хураан авч, Зоонозын өвчин судлалын үндэсний төвд шинжилгээ хийлгэхээр хүлээлгэн өгч, машин тээврийн хэрэгслийг зохих зааврын дагуу халдваргүйтгэл хийсний дараа очих хаягийг тодруулан бүртгэж оруулна.

Дөрөв. Бүрэлдэхүүний эрх, үүрэг

4.1. “Хяналт шалгалт явуулах ажлын хэсэг”-т ажиллаж байгаа Мал эмнэлгийн улсын байцаагч нь хяналтын хэсгийн ахлагч нь байна.

4.2. Хэсгийн ахлагч нь тухайн өдөр өөрийн удирдлагад ажиллаж байгаа ажилтнуудын үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллана.

4.3. Замын цагдаа болон хэв журмын цагдаагийн албан хаагч авто тээврийн шалган бүртгэх товчоодоор дамжин өнгөрч байгаа тээврийн хэрэгслийг зогсоож, үзлэгт оруулах, дэг журмыг сахиулж, үүрэг гүйцэтгэж байгаа бие бүрэлдэхүүний аюулгүй байдлыг хангана.

4.4. Зөрчил илэрсэн иргэдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх, шаардлагатай тохиолдолд хуулийн байгууллагад шилжүүлэн тусгай бүртгэл хөтлөнө.

4.5. Мал эмнэлэг үржлийн үйлчилгээний албаны ариутгагч нар халдваргүйтгэл хийгдээгүй тарваганы арьс, түүхий эд материал авч яваад саатуулагдсан иргэдийн ачаа тээш, машин техник хэрэгслийг ариутгаж халдваргүйжүүлнэ.

4.6. Дүүргийн Эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүд хүн, мал, амьтны гоц халдварт тарваган тахал өвчин илэрсэн болон сэжигтэй иргэдийг тусгаарлах, эмчлэх, хорио цээрийн дэглэм тогтоож, хариу арга хэмжээг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.

4.7. Үүрэг гүйцэтгэж байгаа бүрэлдэхүүн авто тээврийн шалган нэвтрүүлэх товчоогоор дамжин өнгөрөх иргэдэд ухуулга, сурталчилгаа хийх, хүн малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна.

4.8. Онцгой байдлын алба хаагчид захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжлийн байгууллагуудын харилцан ажиллагааг уялдуулан зохион байгуулан ажиллана.

Тав. Хяналт, хариуцлага

5.1. Холбогдох хууль тогтоомж болон энэхүү зааврыг зөрчсөн албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 08 сарын 11-ны өдрийн
А/112 захирамжийн хоёрдугаар хавсралт

ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ БОЛОН ЗАМЫН ЦАГДААГИЙН ХЯНАЛТЫН ЦЭГТ
24 ЦАГААР АЖИЛЛАХ “ХЯНАЛТ ШАЛГАЛТ ЯВУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ” –ИЙН
ХЯНАЛТЫН БАЙР, АЖИЛЛАХ БҮРЭЛДЭХҮҮНИЙ ТОО

№	“Хяналт шалгалт явуулах ажлын хэсэг”-үүдийн байршил	Удирдан зохион байгуулах байгууллага	Хамтран ажиллах	Хугацаа
1.	Багахангай Замын Цагдаагийн пост	Багахангай дүүргийн Засаг даргын Тамгын газар, Онцгой комисс	Онцгой байдлын хэлтэс-1, Мал эмнэлгийн тасаг, улсын байцаагч-1 Замын цагдаа-1	VIII/15-X/15

Тайлбар: Дүүргийн Засаг даргын Тамгын газар, Онцгой комисс нь нутаг дэвсгэрийнхээ авто техникийн шалган бүртгэх товчоон дээр ажиллаж байгаа хяналт шалгалт явуулах ажлын хэсгийн үүрэг гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллана.

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 08 сарын 11 -ны өдрийн
А/168 захирамжийн гуравдугаар хавсралт

ТАРВАГАН ТАХАЛ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ХӨДӨЛГӨӨНТ ЭРГҮҮЛ, ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ХУВААРЬ

д/д	Овог нэр	Эрхэлсэн албан тушаалтан	Эргүүлээр ажиллах хуваарь	
			Эхлэх	Дуусах
1.	Г.Ганзориг	Онцгой байдлын хэлтсийн орлогч, дэд хурандаа	2025.08.15	2025.08.22
2.	Ц.Мягмарсүрэн	Онцгой байдлын хэлтсийн Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагч, дэслэгч	2025.08.22	2025.08.29
3.	Х.Ганбат	Эрүүл мэндийн төвийн дарга	2025.08.29	2025.09.05
4.	Н.Нямзав	1-р хорооны Засаг дарга	2025.09.05	2025.09.12
5.	Б.Батзориг	2-р хорооны Засаг дарга	2025.09.12	2025.09.19
6.	Д.Хүрэлбаатар	Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга	2025.09.19	2025.09.26
7.	Т.Лхагвасүрэн	Цагдаагийн хэлтсийн дарга	2025.09.26	2025.10.03
8.	А.Отгонжаргал	Хөдөө аж ахуйн тасаг	2025.10.03	2025.10.10
9.	Д.Шүрэн-Эрдэнэ	Мал эмнэлгийн тасгийн дарга	2025.10.10	2025.10.15

Тайлбар: Хяналт шалгалтын хэсгүүд нь хяналт шалгалтыг 7 хоногт 1 удаа зохион байгуулж эргүүл шалгалтаар ажилласан тухай дүн мэдээний илтгэх хуудсыг тухай бүр дүүргийн Онцгой байдлын хэлтэст ирүүлнэ.

Хяналт шалгалтаар ажиллах онцгой комиссын гишүүд нь дүүргийн онцгой байдлын хэлтсийн шуурхай албаны автомашинтайгаар эргүүл хяналт шалгалтын ажлыг зохион байгуулна.

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны 08 сарын 11-ны өдрийн
А/108 захирамжийн дөрөвдүгээр хавсралт



ШААРДАГДАХ ШАТАХУУНЫ ТӨСӨВ

№	Материалын нэр	Нэг бүрийн үнэ	7 хоног тутам			Бүгд үнэ
			Литр	Хэдэн удаа	Нийт	
1.	A-92	2610	20	19	380	991,800

УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1.	Тараах материал	500 ш	1000	500,000
2.	Зөөврийн байрны цахилгааны төлбөр	1000 кВт	265.0	265,000
Нийт				765,000

ШАТАХУУН БОЛОН УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН НИЙТ ТӨСӨВ

№	Материалын нэр	Нийт үнэ
1.	Шатахуун	991,800
2.	Урьдчилан сэргийлэх	765,000
Нийт		1,756,800